



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл /Улаанбаатар-Багц-4/ Мамба дацан орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаанд холбох ажлын хүрээнд бий болсон, нийт 368,890,075.00 (гурван зуун жаран найман сая найман зуун ерэн мянга далан таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат, нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, орон нутгийн өмчит эзэмшигчийн үндсэн хөрөнгөд бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын ...-ны өдрийн
33 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон
төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (Tөгрөг)	Нийт үнэ	Хөрөнгийг ашиглагч төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр
1	Тэвшээр хучигдсан суваг	Л9	ш	17	833,737.47	14,173,537.00	Орон нутгийн өмчит Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
2	Хавтангаар хучигдсан суваг	Л4	ш	27	1,300,024.11	35,100,651.00	
3	Бетон дэр		ш	42	19,856.10	833,956.00	
4	Чиг өөрчлөгч	Ф150	ш	14	90,856.07	1,271,985.00	
5	яндан хоолой	Ф150	м	210.6	108,673.64	22,886,669.00	
6	Бөмбөлгөн хаалт	Ф150	ком	2	1,157,838.00	2,315,676.00	
7	Юүлэх хаалт	Ф50	ш	4	298,657.25	1,194,629.00	
8	Угсармал худаг		ш	1	6,095,317.00	6,095,317.00	
9	битум түрхлэг		м2	371.04	10,312.18	3,826,232.00	
10	ДДТ-ийн барилга	6x6	ком	1	262,737,870.00	262,737,870.00	
ДҮН						350,436,522.00	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК
11	Ган чиг өөрчлөгч Ф150	Ф150	ш	2	94,112.00	188,224.00	
12	Бөмбөлгөн хаалт	Ф150	ш	2	948,766.00	1,897,532.00	
13	Угсармал худаг	СП-4	ш	1	10,139,679.00	10,139,679.00	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
ДҮН						12,225,435.00	
14	Кабель	3x70+1x35	м	320	16,424.33	5,255,785.00	
15	Кабелийн зэс тэгсгөвч	70кв.мм	ш	16	1,659.56	26,553.00	-
16	Хуванцар хоолой	d-110 мм	м	135	7,005.78	945,780.00	
ДҮН						6,228,118.00	
Нийт дүн						368,890,075.00	(гурван зуун жаран найман сая найман зуун ерэн мянга далан таван)